

**“ЭВЛЭРҮҮЛЭН ЗУУЧЛАЛЫН ТУХАЙ” ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН
ТӨСӨЛД ХИЙСЭН ЗАРДЛЫН ТООЦОО**

УЛААНБААТАР ХОТ
2025

АГУУЛГА

УДИРТГАЛ.....	2
Үнэлгээний хамрах хүрээ.....	4
Нэг. Иргэн, хуулийн этгээдэд үүсэх зардал, ачаалал.....	8
1.1. Иргэн, хуулийн этгээдэд шинээр үүссэн үүрэг	8
1.2. Хугацаа, зардлын тооцоо	9
1.3. Тоон үзүүлэлт, нийт ачаалал /зардал, хугацаа/.....	11
1.4 Бусад зардал	13
Хоёр. Эвлэрүүлэн зуучлах төв байгуулах, эвлэрүүлэн зуучлалын зөвшөөрөл авахад үүсэх захиргааны зардал.....	14
1.4. Шинээр үүссэн захиргааны үүрэг	14
1.5. Хугацаа, зардлын тооцоо	15
1.6. Тоон үзүүлэлт, нийт ачаалал /зардал, хугацаа/.....	18
1.4 Бусад зардал	19
Гурав. Төрийн байгууллагын зардал	20
1.1. Төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг, нэмэлт ачаалал	20
1.2. Ажил үйлчилгээг гүйцэтгэх хүний нөөц	23
1.3. Нийт гарах хүний нөөцийн зардлын тооцоо, холбогдох нэмэлт зардал	24
1.4. Бусад нэмэлт зардал, нийт зардлын урьдчилсан тооцоо, хувилбар.....	27
Үнэлгээний үр дүн.....	29
Хавсралт 1: Шүүхийн байгууллагад үүссэн ачааллыг тооцоход ашиглах стандарт үйл ажиллагааны хүснэгт	32
Хавсралт 1: Төрийн албан хаагчийн цалингийн нэмэгдлийг тооцоход ашиглах хүснэгт	35
Хавсралт 3: Захиалагчаас ирүүлсэн хуулийн төсөл	36

УДИРТГАЛ

Энэхүү тайланд Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн зардлын тооцоог Засгийн газрын 2016 оны 59 тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ын /цаашид Аргачлал гэх/ дагуу гүйцэтгэж, хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах захиргааны зардлыг урьдчилан тооцов.

Хууль тогтоомжийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо нь 2017 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр хэрэгжиж буй Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу хийгддэг бөгөөд тодорхой харилцааг зохицуулах зорилгоор шинээр боловсруулж буй хууль тогтоомж хэрэгжиж эхэлснээр төрийн байгууллага, хуулийн этгээд болон хувь хүнд хэр хэмжээний зардал, ачаалал үүсэх магадлалыг урьдчилан гаргах зорилготой. Энэ нь аливаа хууль тогтоомжийн улмаас улс орны эдийн засаг болон иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад үүсч байгаа захиргааны зардал, ачааллыг аль болох бага үүсгэх зохицуулалтын хувилбарыг боловсруулахад чухал ач холбогдолтой.

Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл /цаашид хуулийн төсөл гэх/ нь шүүхийн бус (арилжааны эвлэрүүлэн зуучлал) эвлэрүүлэн зуучлалыг бэхжүүлэх, амилуулах, маргаан шийдвэрлэх сонголттой хувилбарыг бий болгох үндсэн зорилготой¹.

Энэ хүрээнд тус хуулийн төслөөр иргэн, хуулийн этгээдэд шинээр үүрэг бий болгоогүй боловч шүүхээс гадуур урьдчилан шийдвэрлэх ажиллагаанд тооцогдох маргааны төрөл нэмэгдсэнтэй холбоотойгоор шүүхээс гадуурх эвлэрүүлэн зуучлалын дэмжлэгтэйгээр байгуулсан гэрээг шүүгчийн захирамжаар баталгаажуулахад үүсэх магадлалтай зардал, ачааллыг тооцов. Мөн эвлэрүүлэн зуучлах төв байгуулах, эвлэрүүлэн зуучлагчийн зөвшөөрөл авах зохицуулалтын хүрээнд үүсэх захиргааны зардлыг тооцов.

Төрийн байгууллагын тухайд хуулийг хэрэгжүүлэгч байгууллагуудад тодорхой шинэ үүрэг бий болгосон. Тодруулбал, эвлэрүүлэн зуучлах төвүүдийн бүтэц зохион байгуулалт, чадавхи, мэргэшсэн байдал зэргийг сайжруулахын тулд эрх зүйн зохицуулалтыг илүү тодорхой болгох хүрээнд Эвлэрүүлэн зуучлалын хороо гэсэн шинэ зохицуулагч бүтэц бий болгож, түүнд эвлэрүүлэн зуучлах төвийн магадлан итгэмжлэлтэй холбогдох үүрэг хариуцуулсан.

Түүнчлэн шүүхээс гадуурх эвлэрүүлэн зуучлах төвүүдээр дамжуулан батлагдсан эвлэрлийн гэрээний гүйцэтгэлтэй холбогдох эрх зүйн зохицуулалтын хүрээнд шүүхээс гадуур урьдчилан шийдвэрлэх ажиллагаанд

¹ Хуулийн төслийн танилцуулгаас.

тооцогдох маргааны төрөл нэмэгдсэнтэй холбоотойгоор шүүхэд нэмэлт ачаалал үүсэх магадлалтай тул үүнийг урьдчилан тооцов. Шүүхээс гадуур урьдчилан шийдвэрлэх ажиллагаанд тооцогдох маргааны төрөл нэмэгдсэнтэй холбоотойгоор шүүхийн дэргэдэх эвлэрүүлэн зуучлалын ачаалал мөн нэмэгдэх бөгөөд болзошгүй зардал, ачааллыг урьдчилан тооцов.

Ийнхүү иргэн, хуулийн этгээдэд үүсэх магадлалтай зарим төрлийн зардал, ачаалал болон эвлэрүүлэн зуучлах төв байгуулах, эвлэрүүлэн зуучлагчийн зөвшөөрөл авахад үүсэх захиргааны зардлыг тооцох, түүнчлэн төрийн байгууллагад үүсэх зардлыг тоймлон гаргаснаар хуулийн хэрэгжилтийг бүрэн хангахад шаардлагатай нэмэлт зардлыг урьдчилан тооцох нь тус тайлангийн үндсэн зорилго болно.

Үнэлгээний хамрах хүрээ

Хуулийн төслөөс сонгон зардал тооцох зохицуулалт буюу үнэлгээний хүрээний тухайд Аргачлалын дагуу иргэн, хуулийн этгээдэд шинээр үүссэн үүрэг, харилцаанаас үүсэх зардал, ачааллыг тооцох буюу өмнө байсан харилцааг зохицуулсан зохицуулалтад өөрчлөлт ороогүй бол зардал, ачааллыг тооцдоггүй. Төрийн байгууллагын хувьд өмнө нь хэрэгжүүлж байсан чиг үүрэгт өөрчлөлт ороогүй бол мөн зардал тооцохгүй бөгөөд хуулийн төсөлд хамаарах үндсэн хэрэгжүүлэгч агентлагт үүсэх ачаалал болон улсын төсөвт их хэмжээгээр үүсгэх зардлыг голчлон тооцох зарчмыг баримталдаг.

Тус хуулийн төслийн хувьд иргэн, хуулийн этгээдэд шинээр үүрэг бий болгоогүй боловч шүүхээс гадуур урьдчилан шийдвэрлэх ажиллагаанд тооцогдох маргааны төрөл нэмэгдсэнтэй холбоотойгоор шүүхээс гадуурх эвлэрүүлэн зуучлалын дэмжлэгтэйгээр байгуулсан гэрээг шүүгчийн захирамжаар баталгаажуулахад зардал, ачаалал үүсэх магадлалтай. Мөн эвлэрүүлэн зуучлах төв байгуулах, эвлэрүүлэн зуучлагчийн зөвшөөрөл авах зохицуулалтын хүрээнд захиргааны зардал үүснэ. Харин төрийн байгууллагын тухайд хуулийг хэрэгжүүлэгч байгууллагуудад тодорхой шинэ үүрэг бий болгосоноос гадна өмнө дурдсан зохицуулалтын хүрээнд шүүх болон шүүхийн дэргэдэх эвлэрүүлэн зуучлалын ачаалал нэмэгдэж болзошгүй юм.

Иймд хуулийн төслөөс дараах зохицуулалтуудыг сонгон төрийн байгууллага, иргэнд үүсэх зардал, ачааллыг тооцов. Үүнд:

1. Иргэн, хуулийн этгээдэд үүсэх зардал, ачааллыг тооцох зохицуулалт

Иргэн болон хуулийн этгээдэд үүсэх нэмэлт ачаалал, зардлын хүрээнд шүүхээс гадуурх эвлэрүүлэн зуучлалаар шийдвэрлүүлэх зохицуулалт нь шинээр бий болгосон маргаан шийдвэрлүүлэх хувилбар бус одоогийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуульд байгаа зохицуулалт болохыг онцлох нь зүйтэй. Өөрөөр хэлбэл энд зөвхөн тус хуулийн төслөөр иргэн, аж ахуй нэгжид шинээр бий болгож байгаа ачаалал, зардлыг авч үзэх юм.

Хуулийн төсөлд энэ хүрээнд өмнө нь байгаагүй цоо шинэ зохицуулалт үүсгэсэн буюу иргэн, хуулийн этгээдэд хамаарах үүрэг бий болгосон зохицуулалт тусгагдаагүй байна. Харин одоогийн хуульд байгаа ч шинэчлэл хийгдсэн зохицуулалт болох шүүхээс гадуурх эвлэрүүлэн зуучлалын дэмжлэгтэйгээр байгуулсан гэрээг шүүгчийн захирамжаар баталгаажуулах зохицуулалтын хүрээнд үүсэх магадлалтай зардал, ачааллыг тооцлоо. Гэхдээ энэ нь шүүхээс гадуур урьдчилан шийдвэрлэх ажиллагаанд тооцогдох маргааны төрөл нэмэгдсэнтэй холбоотойгоор үүсэх магадлалтай зардал, ачаалал болно. Үүнд:

Хүснэгт 1. Иргэн, хуулийн этгээдэд үүсэх зардал тооцох зохицуулалт

**Иргэн, хуулийн
этгээдэд үүсэх
зардал, ачаалал**

- 31.1. Төвийн эвлэрүүлэн зуучлагчийн дэмжлэгтэйгээр байгуулсан эвлэрлийн гэрээгээр хүлээсэн үүргээ сайн дураар биелүүлээгүй бол эвлэрлийн гэрээ зөрчигдэж эхэлсэн үеэс үүрэг гүйцэтгэгчийн харьяа дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхэд хүсэлт гарган эвлэрлийн гэрээг шүүгчийн захирамжаар баталгаажуулна.

Өөрөөр хэлбэл тус зохицуулалтын хүрээнд шүүхэд хүсэлт гаргаж эвлэрлийн гэрээг шүүгчийн захирамжаар баталгаажуулахад үүсэх зардлыг тооцно.

2. Эвлэрүүлэн зуучлах төв байгуулах, эвлэрүүлэн зуучлагчийн зөвшөөрөл авах захиргааны зардлыг тооцох зохицуулалт

Эвлэрүүлэн зуучлах Төв байгуулах этгээдэд үүсэх зардал, ачааллын хувьд шүүхээс гадуурх эвлэрүүлэн зуучлалаар шийдвэрлүүлэх зохицуулалт нь одоогийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуульд байгаа зохицуулалт болохыг дахин онцолж байна. Иймд иргэн, аж ахуй нэгжид үүсэх зардлын адил мөн зөвхөн тус хуулийн төслөөр шинээр бий болгож байгаа ачаалал, зардлыг авч үзнэ. Хуулийн төсөлд энэ хүрээнд авч үзэх шаардлагатай дараах зохицуулалт тусгагдсан байна. Үүнд:

Хүснэгт 5. Эвлэрүүлэн зуучлах төв байгуулахад үүсэх захиргааны зардал тооцох зохицуулалт

**Эвлэрүүлэн
зуучлах төв
байгуулахад
үүсэх
захиргааны
зардал**

- 10.1. Дараах шаардлагыг хангасан Төв магадлан итгэмжлүүлэх хүсэлтийг Хорооны ажлын албандаа гаргана;
- 10.2. Магадлан итгэмжлүүлэх хүсэлтэд дараах бичиг баримтыг хавсаргана

Харин эвлэрүүлэн зуучлагчийн зөвшөөрөл авах этгээдэд захиргааны зардал үүсгэсэн дараах зохицуулалт хуулийн төсөлд тусгагдсан байна. Үүнд:

Хүснэгт 5. Эвлэрүүлэн зуучлалын зөвшөөрөл авахад үүсэх захиргааны зардал тооцох зохицуулалт

**Эвлэрүүлэн
зуучлалын
зөвшөөрөл
авахад үүсэх
захиргааны**

- 11.1. Энэ хуульд заасан шаардлага хангасан эвлэрүүлэн зуучлагч нь холбогдох нотлох баримтын хамт эвлэрүүлэн зуучлагчийн эрх авахаар хүсэлтээ Хорооны ажлын албандаа гаргана.

зардал

Өөрөөр хэлбэл эвлэрүүлэн зуучлах төв байгуулах болон эвлэрүүлэн зуучлах зөвшөөрөл авахад үүсэх зардал, ачааллын хүрээнд хуулийн төсөлд тусгагдсан захиргааны үүргийг гүйцэтгэхтэй холбогдуулан гарах мөнгөн зардлаас гадна зарцуулах хугацаа буюу ачааллыг тооцно.

3. Төрийн байгууллагад шинээр үүсэх зардал, ачааллыг тооцох зохицуулалт

Төрийн байгууллагад үүсэх зардал, ачааллын хувьд хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон шүүхийн байгууллагад үүсэх зардал, ачааллыг тооцов. Үүнд:

(а). Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад үүсэх зардал, ачааллыг тооцох зохицуулалт

Хууль зүйн яамны хувьд эвлэрүүлэн зуучлах төвийн талаарх зохицуулалтыг шинэчилсэнтэй холбоотойгоор шинээр үүсгэж буй бүтэц болох Хороо, түүний ажлын албаны зардал үүснэ. Үүнд:

Хүснэгт 5. Хороо болон түүний ажлын албаны зардал

Хорооны цалин хангамж

- 9.1.Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэд орон тооны бус Хороо ажиллана.
- 9.2.Хороо нь 7 гишүүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд даргыг нь гишүүдийн олонхын саналаар хорооны даргыг дотроосоо сонгоно.
- 9.3.Хорооны бүрэлдэхүүнд хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас хоёр, шүүгч, эвлэрүүлэн зуучлагч, хуульчдын холбоо, өмгөөлөгчдийн холбооны төлөөлөл, их сургуулийн багш тус бүр нэг байх бөгөөд хорооны гишүүний бүрэн эрхийн хугацаа 4 жил байна.

Ажлын албаны цалин хангамж

9.5.Хороо бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд туслалцаа үзүүлэх, Хорооны үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөлийг хангах чиг үүрэг бүхий ажлын албатай байна. Хорооны ажлын албаны чиг үүргийг Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын нэгж хэрэгжүүлнэ.

(б). Шүүхийн байгууллага болон шүүхийн дэргэдэх эвлэрүүлэн зуучлалд үүсэх зардал, ачааллыг тооцох зохицуулалт

Шүүхийн байгууллагад үүсэх магадлалтай ачааллын хувьд шүүхээс гадуурх эвлэрүүлэн зуучлалын дэмжлэгтэйгээр байгуулсан гэрээ зөрчигдөж эхэлсэн үед шүүхэд гаргасан хүсэлтийг шийдвэрлэх, шүүгчийн захирамжаар баталгаажулахтай холбоотойгоор шүүхийн ачаалал нэмэгдэх магадлалтай тул ачааллыг урьдчилан тооцох шаардлагатай гэж үзлээ. Энэхүү зохицуулалтын хувьд иргэн, хуулийн этгээдэд үүсэх зардал, ачаалалыг тооцоход авч үзсэнтэй адилаар нэмэлт ачаалал үүсэх магадлалтай юм. Түүнчлэн шүүхээс гадуур урьдчилан шийдвэрлэх ажиллагаанд тооцогдох маргааны төрөл нэмэгдсэнтэй холбоотойгоор шүүхийн эвлэрүүлэн зуучлалын ачаалал нэмэгдэнэ. Үүнд:

Хүснэгт 5. Шүүхийн байгууллагад үүсэх зардал, ачаалал

Шүүхийн байгууллагад үүсэх зардал, ачаалал

Шүүхийн эвлэрүүлэн зуучлалд үүсэх зардал, ачаалал

- 31.1.Төвийн эвлэрүүлэн зуучлагчийн дэмжлэгтэйгээр байгуулсан эвлэрлийн гэрээгээр хүлээсэн үүргээ сайн дураар биелүүлээгүй бол эвлэрлийн гэрээ зөрчигдөж эхэлсэн үеэс үүрэг гүйцэтгэгчийн харьяа дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхэд хүсэлт гарган эвлэрлийн гэрээг шүүгчийн захирамжаар баталгаажуулна.
- 6.5.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 132.4-т зааснаас бусад гэр бүлийн харилцаанаас үүссэн маргаан, түрээс болон эд хөрөнгө хөлслөх гэрээний маргаан, хөршийн эрхийн маргаан, сууц өмчлөгчдийн холбооны маргаанд эвлэрүүлэн зуучлалыг урьдчилан шийдвэрлэх ажиллагааны журмаар хэрэглэнэ.

Нэг. Иргэн, хуулийн этгээдэд үүсэх зардал, ачаалал

Энэ хэсэгт хуулийн төсөлд шинээр тусгагдсан зохицуулалт хэрэгжихэд иргэн, хуулийн этгээдэд үүсэх мөнгөн зардлаас гадна зарцуулах хугацаа буюу ачааллыг тооцно. Ингэхдээ Аргачлалын дагуу хуулийн төсөл нь шинэ хууль буюу анхдагч хуулийн төсөл бус шинэчилсэн найруулга бол шинээр үүрэг, ачаалал бий болгосон зохицуулалтад л зардал тооцдог.

Тус хуулийн төсөлд өмнө нь байгаагүй цоо шинэ зохицуулалт үүсгэсэн буюу иргэн, хуулийн этгээдэд хамаарах үүрэг бий болгосон зохицуулалт тусгагдаагүй. Гэхдээ одоогийн хуульд байгаа ч шинэчлэл хийгдсэн зохицуулалт болох шүүхээс гадуурх эвлэрүүлэн зуучлалын дэмжлэгтэйгээр байгуулсан гэрээг шүүгчийн захирамжаар баталгаажуулах зохицуулалтын хүрээнд үүсэх магадлалтай зардал, ачааллыг авч үзэх шаардлагатай гэж үзэн зардлын тооцоолол гаргав. Энэ нь шүүхээс гадуур урьдчилан шийдвэрлэх ажиллагаанд тооцогдох маргааны төрөл нэмэгдсэнтэй холбоотойгоор үүсэх магадлалтай зардал, ачаалал болно.

Зардлыг Аргачлалд заасны дагуу дараах 5 алхам буюу үе шатаар тооцов. Үүнд:

- Үүргийг тогтоох
- Хугацаа зардал тооцох
- Тоон үзүүлэлтийг тооцох
- Нийт дүнг тооцож гаргах
- Хувилбарыг нягталж, хялбарчлах боломжийг шалгах

1.1. Иргэн, хуулийн этгээдэд шинээр үүссэн үүрэг

Дээр дурдсан одоогийн хуульд байгаа ч шинэчлэл хийгдсэн зохицуулалт болох шүүхээс гадуурх эвлэрүүлэн зуучлалын дэмжлэгтэйгээр байгуулсан гэрээг шүүгчийн захирамжаар баталгаажуулах зохицуулалтын хүрээнд үүсэх магадлалтай зардал, ачааллыг хуулийн төслийн дараах зохицуулалтын хүрээнд тооцов. Үүнд:

Хүснэгт 22. Иргэн, хуулийн этгээдэд ачаалал бий болгох заалт

№	Холбогдох зохицуулалт	Тооцох зардал
1	29.1. Энэ хуулийн 8 дугаар зүйлд заасан Эвлэрүүлэн зуучлах төвийн эвлэрүүлэн зуучлагчийн дэмжлэгтэйгээр байгуулсан эвлэрлийн гэрээгээр хүлээсэн үүргээ сайн дураар биелүүлээгүй бол эвлэрлийн гэрээ зөрчигдөж эхэлсэн үеэс үүрэг гүйцэтгэгчийн харьяа дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхэд хүсэлт гарган эвлэрлийн	Шүүхэд хүсэлт гаргаж эвлэрлийн гэрээг шүүгчийн захирамжаар баталгаажуулах

гэрээг шүүгчийн захирамжаар баталгаажуулна.

1.2. Хугацаа, зардлын тооцоо

Энэ хэсэгт тодорхойлсон үүргийг гүйцэтгэхэд хуулийн этгээд, иргэдээс зарцуулах цаг хугацаа, мөнгөн зардлыг тооцож гаргав. Ингэхдээ:

- Үйлдэл буюу стандарт үйл ажиллагааг тодорхойлж,
- Үйлдэлд зарцуулах хугацааг тогтоож,
- Тэдгээрт зарцуулах зардлыг тодорхойлов.

Тус зохицуулалттай холбоотой үүсэх цаг хугацааны ачааллыг тооцохдоо стандарт үйл ажиллагааг ярилцлагын аргаар тодорхойлж улмаар зарцуулах цаг хугацааг дундаж байдлаар таамаглан тогтоов. Үүнд:

Хүснэгт 23. Үйл ажиллагааг гүйцэтгэх шаардлагатай хугацаа болон зардал

№	Үүрэг	Агуулга	Стандарт ажиллагаа	үйл хугацаа /мин/
1	Шүүхэд эвлэрлийн гэрээг шүүгчийн захирамжаар баталгаажуулах хүсэлт гаргах	Үүрэгтэй танилцах		20
2		Мэргэжлийн зөвлөгөө авах		60
3		Мэдээлэл цуглуулах, цуглувалсан мэдээллийг нэгтгэх		20
4		Цуглувалсан боловсруулах	мэдээллээ	60
5		Албан бичгийн шаардлага		5
6		Албан бичиг боловсруулах		15
7		Холбогдох газарт илгээх		5
8		Төлбөр хийх		15

Ийнхүү иргэн болон хуулийн этгээд тус зохицуулалтыг ашиглах шаардлагатай бол дунджаар **200 мин** зарцуулах тооцоо гарч байна.

Харин эдгээр стандарт үйл ажиллагааг гүйцэтгэхэд зарцуулах цаг хугацааг мөнгөн зардлаар илэрхийлэх тухайд энэ нь зөвхөн хуулийн этгээдэд хамаарна. Иргэнд үүсэх зардлын хувьд зардал, ачааллыг зөвхөн зарцуулах цаг хугацаагаар илэрхийлэхэд Аргачлалын шаардлагыг хангана.

Тус зохицуулалтыг ашиглах шаардлагатай болсон хуулийн этгээдийн хувьд дээрх стандарт алхамуудад зарцуулах хугацааг ажилтны цалинд шилжүүлж мөнгөн зардлыг гаргах шаардлагатай. Харин ажлын хөлсийг тогтоохдоо аж ахуй нэгжид ажиллаж буй нэг ажилтны сарын дундаж цалин хөлсийг баримжаалан тооцов. Үүнд:

Хүснэгт 2. Аж ахуйн нэгж, байгууллагын ажиллагчдын сарын дундаж цалин²

Он	2019	2020	2021	Дундаж дүн
Улсын дундаж цалин	1,124,3 00	1,120,6 00	1,279,4 00	1,174,8 00

Ийнхүү сүүлийн гурван жилийн дундаж цалинд үндэслэн ажилтны нэг сарын ажлын хөлсийг **1,174,800** төгрөг байхаар тогтоож, ажиллах хугацааг хөдөлмөрийн харилцааг зохицуулж буй хууль тогтоомжид заасан ажлын хоног, ажиллах цагт үндэслэв. Иймд:

Хүснэгт 3. Аж ахуйн нэгжид хөдөлмөр эрхэлж буй ажилтны ажлын хөлс цаг, минутаар

Үндсэн цалин	Ажиллах хугацаа	Ажлын хөлс
1,174,800	176 цаг	6675 төг /цагт/

²

http://1212.mn/tables.aspx?tbl_id=DT_NSO_0400_022V1&Salbar_select_all=0&SalbarSingleSelect= 1&Gender_select_all=0&GenderSingleSelect= 1&YearQ_select_all=0&YearQSingleSelect=&YearY_select_all=0&YearYSingleSelect= 2020_2019_2021&viewtype=table, сүүлд нэвтэрсэн 2022 оны 9 дүгээр сарын 1.

1,174,800	10560 мин	111 төг /мин/
-----------	-----------	---------------

Энэхүү тооцоонд үндэслэн тус зохицуулалтыг ашиглах шаардлагатай болсон хуулийн этгээдэд гарах мөнгөн зардлыг тооцов. Үүнд:

Хүснэгт 23. Үргийг гүйцэтгэх шаардлагатай хугацаа болон зардал

№	Үүрэг	Нийт зарцуулах хугацаа /мин/	Ажлын /төг/	хөлс	Зардал /төг/
---	-------	------------------------------	-------------	------	--------------

1	Шүүхэд хүсэлт гаргаж эвлэрлийн шүүгчийн захирамжаар баталгаажуулах	200	111	22200
---	--	-----	-----	-------

Нийт зардал	22200
-------------	-------

Ийнхүү тус зохицуулалтыг ашиглах шаардлагатай болсон хуулийн этгээд дунджаар **200 мин** зарцуулах буюу **22200 төг** зарцуулах тооцоо гарч байна.

1.3. Тоон үзүүлэлт, нийт ачаалал /зардал, хугацаа/

Тоон үзүүлэлт нь хуулийн төсөлд тусгасан үүргийг хичнээн этгээдэд нэг жилд хэдэн удаагийн давтамжтайгаар хүлээлгэж байгааг илэрхийлдэг. Үүнд:

- Тохиолдлын тоо
- Дамтамжийн тоо

Тохиолдлын тоо, давтамжийн тоог тодорхойлсны дараа тэдгээрийн үржвэрийн тоон үзүүлэлт нь илэрхийлэгдэнэ. Тус зохицуулалтын хувьд давтамжийн тоо нь 1 байх бөгөөд тохиолдлын тоо нь шүүхээс гадуур урьдчилан шийдвэрлэх ажиллагаанд тооцогдох болж нэмэгдсэн маргааны төрлүүдийн тохиолдлын тоо байна. Иймд тохиолдлын тоо буюу эдгээр төрлийн маргааны сүүлийн 3 жилийн дундаж тоо, статистикиг авч үзэв.

№	2022 он	2023 он	2024 он	Сүүлийн 3 жилийн дундаж
---	---------	---------	---------	-------------------------------

1	Түрээсийн гэрээтэй холбоотой хэргийг хянан шийдвэрлэсэн тоо	626	608	695	643
2	Эд хөрөнгө хөлслөх гэрээтэй холбоотой хэргийг хянан шийдвэрлэсэн тоо	18	6	5	10
3	Сууц өмчлөгчдийн холбооны хэргийг хянан шийдвэрлэсэн тоо	829	725	683	746
4	Нийт	1473	1339	1383	1398

Улмаар өмнөх шатанд тооцож гаргасан үйл ажиллагаанд иргэний зарцуулах хугацаа, хуулийн этгээдийн зарцуулах мөнгөн зардлыг тоон үзүүлэлтүүдэд үржүүлж нийт зардлын дүнг гаргавал дараах дүн гарна. Үүнд:

Хүснэгт 24. Иргэд, хуулийн этгээдэд бий болох нийт зардал

№	Маргааны төрөл	Хугацаа /мин/	Тохиолдол	Зардал /төг/	Тохиолд ол
1	Түрээсийн гэрээтэй холбоотой хэргийг хянан шийдвэрлэсэн тоо	200	643	22200	643
2	Эд хөрөнгө хөлслөх гэрээтэй холбоотой хэргийг хянан шийдвэрлэсэн тоо		10		10
3	Сууц өмчлөгчдийн холбооны хэргийг хянан		746		746

шийдвэрлэсэн тоо

Нийт

279600

31035600

Ийнхүү хуулийн төсөлд тусгагдсан тус зохицуулалтыг ашиглах шаардлага үүсэх магадлалтай **НИЙТ ТОХИОЛДЛООР** авч үзвэл иргэдэд **279600 МИНУТЫН** ачаалал, хуулийн этгээдэд **31035600** орчим төгрөгийн зардлын ачаалал бий болох магадлалтай.

1.4 Бусад зардал

Хуулийн төсөлд дээрх харилцаатай холбоотойгоор нэмэлт зардал үүсэхгүй болно.

Хоёр. Эвлэрүүлэн зуучлах төв байгуулах, эвлэрүүлэн зуучлалын зөвшөөрөл авахад үүсэх захиргааны зардал

Энэ хэсэгт Аргачлалын дагуу хуулийн төсөлд заасан нэмэлт захиргааны үүргийг хэрэгжүүлэхэд эвлэрүүлэн зуучлах төв байгуулах этгээд, эвлэрүүлэн зуучлагчид үүсэх зардал, ачааллын хүрээнд гарах мөнгөн зардлаас гадна зарцуулах хугацаа буюу ачааллыг тооцно. Ингэхдээ тус хуулийн төсөл нь шинэ хууль буюу анхдагч хуулийн төсөл бус шинэчилсэн найруулга тул шинээр үүрэг, ачаалал бий болгосон зохицуулалтад зардал тооцов. Зардлыг Аргачлалд заасны дагуу дараах 5 алхам буюу үе шатаар тооцно. Үүнд:

- Үүргийг тогтоох
- Хугацаа зардал тооцох
- Тоон үзүүлэлтийг тооцох
- Нийт дүнг тооцож гаргах
- Хувилбарыг нягталж, хялбарчлах боломжийг шалгах

1.4. Шинээр үүссэн захиргааны үүрэг

Аргачлалд заасны дагуу шинээр үүссэн үүрэг, харилцаанаас үүсэх зардал, ачааллыг тооцох буюу өмнө байсан харилцааг зохицуулсан зохицуулалтад өөрчлөлт ороогүй бол зардал, ачааллыг тооцдоггүй. Энэ хүрээнд тус хуулийн төсөлд эвлэрүүлэн зуучлах төв байгуулах, эвлэрүүлэн зуучлалын зөвшөөрөл авахтай холбоотойгоор шинээр захиргааны үүрэг хүлээлгэсэн дараах зохицуулалт байна. Үүнд:

Хүснэгт 22. Шинээр ачаалал бий болгосон заалт /Захиргааны зардал үүсгэх/

№	Холбогдох зохицуулалт	Тооцох зардал
Эвлэрүүлэн зуучлах төв байгуулах		
1	10.2. Магадлан итгэмжлүүлэх хүсэлт гаргаж буй этгээд нь дараах зүйлсийг тусгасан хүсэлт, баримтыг хавсарган Хорооны ажлын албанд гаргана.	Холбогдох бичиг баримт бүрдүүлж магадлан итгэмжлүүлэх хүсэлт гаргах
	10.2.1. Эвлэрүүлэн зуучлах төвийн нэр, хуулийн этгээдийн дэргэд байгуулагдах бол тухайн хуулийн этгээдийн нэр, хаяг, тухайн эвлэрүүлэн зуучлах төвийг төлөөлөх эрх бүхийн этгээдийн овог нэр, хаяг;	
	10.2.2. Эвлэрүүлэн зуучлах төвийн байрлах байрны хаяг, байршил;	
	10.2.3. Хуулийн этгээдийн хэлбэрээр байгуулагдсан эвлэрүүлэн зуучлалын төв бол байгууллагын дүрэм,	

энэ хуулийн 10.1-т заасан шаардлагыг хангасан дүрэм журам, холбогдох баримт бичиг;

10.2.4. Төрийн болон ашгийн бус байгууллагын дэргэд байгуулагдаж буй эвлэрүүлэн зуучлах төв бол тухайн төрийн болон ашгийн бус байгууллагын дүрэм, энэ хуулийн 10.1-т заасан шаардлагыг хангасан дүрэм журам, холбогдох баримт бичиг;

10.2.5. Эвлэрүүлэн зуучлах төвийн үйл ажиллагааны журам болон үйл ажиллагааны төлөвлөгөө;

10.2.6. Журамд заасан бусад бичиг баримт.

Эвлэрүүлэн зуучлалын зөвшөөрөл авах

2	10.4. Энэ хуульд заасан шаардлага хангасан эвлэрүүлэн зуучлагч нь холбогдох нотлох баримтын хамт эвлэрүүлэн зуучлагчийн зөвшөөрөл авахаар хүсэлтээ Хорооны ажлын албанд гаргана.	Холбогдох нотлох баримт бүрдүүлж зөвшөөрөл авах хүсэлт гаргах
---	--	---

1.5. Хугацаа, зардлын тооцоо

Энэ хэсэгт тодорхойлсон үүргийг гүйцэтгэхэд зарцуулах цаг хугацаа, мөнгөн зардлыг тооцож гаргав. Ингэхдээ:

- Үйлдэл буюу стандарт үйл ажиллагааг тодорхойлж,
- Үйлдэлд зарцуулах хугацааг тогтоож,
- Тэдгээрт зарцуулах зардлыг тодорхойлов.

Үүргийг гүйцэтгэхэд үүсэх цаг хугацааны ачааллыг тооцохдоо стандарт үйл ажиллагааны жагсаалтад үндэслэж зарцуулах цаг хугацааг тодорхойлов. Үүнд:

Хүснэгт 23. Үүргийг гүйцэтгэх шаардлагатай хугацаа болон зардал

№	Үүрэг	Стандарт үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа /мин/
1	Холбогдох бичиг баримт бүрдүүлж магадлан итгэмжлүүлэх хүсэлт	Үүрэгтэй танилцах судлах	120
2		Мэдээлэл цуглуулах	120

	гаргах		
3		Маягт бөглөх, гарчиглах, тэмдэглэх	30
4		Тооцоо хийх	120
5		Мэдээлэл, өгөгдөхүүнийг нягтлах	60
6		Алдааг засах	60
7		Тоо баримтыг боловсруулах	120
8		Мэдээлэл шилжүүлэх болон нийтлүүлэх	10
9		Дотоод хуралдаан	480
10		Бусадтай хамтран хийх хуралдаан	480
11		Мөнгөн шилжүүлгийн үүрэг	30
12		Олшруулах, архивлах, тараах	10
13		Төрийн захиргааны байгууллагаас 30 шалгах	
14		Төрийн захиргааны байгууллагын 90 шалгалтын дүнгээс үүдэлтэй засвар, өөрчлөлт	
Нийт			1760
1	Холбогдох нотлох баримт бүрдүүлж зөвшөөрөл авах хүсэлт гаргах	Үүрэгтэй танилцах	20
2		Мэдээлэл цуглуулах, нэгтгэх	80
3		Мэдээлэл боловсруулах	20

4	Маягт бөглөх	25
5	Албан бичиг боловсруулах	15
6	Мэдээллээ илгээх, хүргүүлэх	10
Нийт		170

Ийнхүү эвлэрүүлэн зуучлах төв байгуулах этгээд хуулийн төсөлд заасан захиргааны үүргийг биелүүлэхэд дунджаар **1760 мин** зарцуулж, харин эвлэрүүлэн зуучлалын зөвшөөрөл авах этгээд дунджаар **170 мин** зарцуулах тооцоо гарч байна.

Эдгээр стандарт үйл ажиллагааг гүйцэтгэхэд зарцуулах цаг хугацааг мөнгөн зардлаар илэрхийлэх тухайд энэ нь зөвхөн эвлэрүүлэн зуучлах төв байгуулах этгээдэд хамаарна. Эвлэрүүлэн зуучлалын зөвшөөрөл авах хувь хүний хувьд зардал, ачааллыг зөвхөн зарцуулах цаг хугацаагаар илэрхийлэхэд Аргачлалын шаардлагыг хангана.

Эвлэрүүлэн зуучлах төв байгуулах хуулийн этгээдийн хувьд тухайн үүргийг гүйцэтгэхэд зарцуулах хугацааг ажилтны цалинд шилжүүлж мөнгөн зардлыг гаргах шаардлагатай. Харин ажлын хөлсийг тогтоохдоо аж ахуй нэгжид ажиллаж буй нэг ажилтны сарын дундаж цалин хөлсийг баримжаалан тооцов. Үүнд:

Хүснэгт 2. Аж ахуйн нэгж, байгууллагын ажиллагчдын сарын дундаж цалин³

Он	2019	2020	2021	Дундаж дүн
Улсын дундаж цалин	00 1,124,3	00 1,120,6	00 1,279,4	00 1,174,8

Ийнхүү сүүлийн гурван жилийн дундаж цалинд үндэслэн ажилтны нэг сарын ажлын хөлсийг **1,174,800** төгрөг байхаар тогтоож, ажиллах хугацааг

³

http://1212.mn/tables.aspx?tbl_id=DT_NSO_0400_022V1&Salbar_select_all=0&SalbarSingleSelect_=1&Gender_select_all=0&GenderSingleSelect_=1&YearQ_select_all=0&YearQSingleSelect=&YearY_select_all=0&YearYSingleSelect_=2020_2019_2021&viewtype=table, сүүлд нэвтэрсэн 2022 оны 9 дүгээр сарын 1.

хөдөлмөрийн харилцааг зохицуулж буй хууль тогтоомжид заасан ажлын хоног, ажиллах цагт үндэслэв. Иймд:

Хүснэгт 3. Аж ахуйн нэгжид хөдөлмөр эрхэлж буй ажилтны ажлын хөлс цаг, минутаар

Үндсэн цалин	Ажиллах хугацаа	Ажлын хөлс
1,174,800	176 цаг	6675 төг /цагт/
1,174,800	10560 мин	111 төг /мин/

Энэхүү тооцоонд үндэслэн эвлэрүүлэн зуучлах төв байгуулах этгээд хуулийн төсөлд заасан захиргааны үүргийг биелүүлэхэд гарах мөнгөн зардлыг тооцов. Үүнд:

Хүснэгт 23. Үүргийг гүйцэтгэх шаардлагатай хугацаа болон зардал

№	Үүрэг	Нийт зарцуулах хугацаа /мин/	Ажлын хөлс /төг/	Зардал /төг/
---	-------	------------------------------	------------------	--------------

1	Холбогдох бичиг баримт бүрдүүлж магадлан итгэмжлүүлэх хүсэлт гаргах	1760	111	195360
---	---	------	-----	--------

Нийт зардал	195360
-------------	--------

Ийнхүү эвлэрүүлэн зуучлах төв байгуулах этгээд хуулийн төсөлд заасан захиргааны үүргийг биелүүлэхэд дунджаар **1760 мин** зарцуулах буюу **195360 төг** зарцуулах тооцоо гарч байна.

1.6. Тоон үзүүлэлт, нийт ачаалал /зардал, хугацаа/

Тоон үзүүлэлт нь хуулийн төсөлд тусгасан үүргийг хичнээн этгээдэд, нэг жилд хэдэн удаагийн давтамжтайгаар үүрэг хүлээлгэж байгааг илэрхийлнэ. Үүнд:

- Тохиолдлын тоо
- Дамтамжийн тоо

Тохиолдлын тоо, давтамжийн тоог тодорхойлсны дараа тэдгээрийн үржвэрийн тоон үзүүлэлт нь илэрхийлэгдэнэ. Эдгээр зохицуулалтын хувьд давтамжийн тоо нь 1 удаа байх боловч тохиолдлын тоо нь тухайн харилцааны зах зээлийн эрэлт, нийлүүлэлтээс шалтгаалан.

Иймд тус хуулийн төсөлд тусгагдсан эвлэрүүлэн зуучлах төв байгуулах болон эвлэрүүлэн зуучлалын зөвшөөрөл авахад 1 удаа биелүүлэх зохицуулалтын хүрээнд **нийт тохиолдлыг** авч үзэх шаардлагагүй болно.

1.4 Бусад зардал

Хуулийн төсөлд дээрх харилцаатай холбоотойгоор нэмэлт зардал үүсэхгүй болно.

Гурав. Төрийн байгууллагын зардал

Энэ хэсэгт хуулийн төслийн төрийн захиргааны байгууллагад үүрэг оногдуулсан зохицуулалтууд нь тухайн байгууллагад буюу төрд хэдий хэр ачаалал, зардал үүсгэх магадлалтайг баримжаалан тооцно. Төрийн байгууллагад үүсэх ачаалал, зардлын хэмжээг урьдчилан тооцох нь тухайн зохицуулалтыг хэрэгжүүлэх төсөв, санхүүжилтийн хэмжээ, хэрэгцээ, шаардлагыг тогтоох, мөн хэрэгжих боломжийг тодорхойлоход ач холбогдолтой.

Төрийн байгууллага буюу улсын төсөвт үүсэх зардлыг дараах үе шатаар тооцно. Үүнд:

- Үүргийг тогтоох
- Хүний нөөцийг тодорхойлох
- Гарах зардлыг тооцох
- Зардлыг нэгтгэн тооцож гаргах
- Хувилбарыг нягталж, танилцуулах

1.1. Төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг, нэмэлт ачаалал

Төрийн байгууллагад үүсэх зардал, ачааллын хувьд хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон шүүх, шүүхийн дэргэдэх эвлэрүүлэн зуучлалд үүсэх зардал, ачааллыг тооцов.

Тодруулбал, Хууль зүйн яамны хувьд эвлэрүүлэн зуучлах төвийн талаарх зохицуулалтыг шинэчилсэнтэй холбоотойгоор шинээр үүсгэж буй бүтэц болох Хороо, түүний ажлын албаны зардал үүснэ. Шүүхийн байгууллагад үүсэх магадлалтай ачааллын хувьд шүүхээс гадуурх эвлэрүүлэн зуучлалын дэмжлэгтэйгээр байгуулсан гэрээ зөрчигдэж өхэлсэн үед шүүхэд гаргасан хүсэлтийг шийдвэрлэх, шүүгчийн захирамжаар баталгаажуулахтай холбоотойгоор шүүхийн ачаалал нэмэгдэх магадлалтай тул ачааллыг урьдчилан тооцох шаардлагатай гэж үзлээ. Энэхүү зохицуулалтын хувьд иргэн, хуулийн этгээдэд үүсэх зардал, ачаалалыг тооцоход авч үзсэнтэй адилаар шүүхээс гадуур урьдчилан шийдвэрлэх ажиллагаанд тооцогдох маргааны төрөл нэмэгдсэнтэй холбоотойгоор нэмэлт ачаалал үүсэх магадлалтай юм. Түүнчлэн тус зохицуулалтын хүрээнд шүүхийн эвлэрүүлэн зуучлалд нэмэлт ачаалал үүснэ. Үүнд:

Хүснэгт 7. Хэрэгжүүлэгч байгууллагуудын үүрэг

№	Зохицуулалт	Зардал тооцох утга
1.	Хууль зүйн яаманд хамаарах	

- 9.1. Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв
1 байгууллагын дэргэд орон тооны бус Эвлэрүүлэн Хорооны гишүүдийн
зуучлалын хороо ажиллана. цалин, хангамж
- 9.2. Хороо нь 7 гишүүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд
даргыг нь гишүүдийн олонхын саналаар дотроосоо
сонгоно.
- 2 9.4. Хороо бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд туслалцаа үзүүлэх, Ажлын албаны цалин,
Хорооны үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөлийг хангамж
хангах чиг үүрэг бүхий ажлын албыг Хууль зүйн асуудал
эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын нэгж
хариуцна.

2. Шүүх, шүүхийн эвлэрүүлэн зуучлал

- 3 29.1. Энэ хуулийн 8 дугаар зүйлд заасан Эвлэрүүлэн Эвлэрэлийн гэрээг зуучлах төвийн эвлэрүүлэн зуучлагчийн дэмжлэгтэйгээр шүүгчийн захирамжаар байгуулсан эвлэрлийн гэрээгээр хүлээсэн үүргээ сайн баталгаажуулахад үүсэх дураар биелүүлээгүй бол эвлэрлийн гэрээ зөрчигдэж зардал, ачаалал эхэлсэн үеэс үүрэг гүйцэтгэгчийн харьяа дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхэд хүсэлт гарган эвлэрлийн гэрээг шүүгчийн захирамжаар баталгаажуулна.
- 4 6.5. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай Шүүхээс гадуур хуулийн 132.4-т зааснаас бусад гэр бүлийн харилцаанаас урьдчилан шийдвэрлэх зээлтэй холбоотой маргаан, банкнаас олгох ажиллагаанд тооцогдох эд хөрөнгө хөлслөх гэрээний маргаан, нэмэлт маргааны зээлтэй холбоотой маргаан, байгууллагаас олгох зээлтэй холбоотой маргааны эвлэрүүлэн зуучлах ажиллагааг шүүхээс гадуур урьдчилан шийдвэрлэх ажиллагаа гэж үзнэ.

Эдгээрээс Хорооны гишүүдийн цалин болон түүний ажлын албаны цалин, хангамжийг нийт гарах хүний нөөцийн зардалд шууд тооцоолох бол шүүх, шүүхийн эвлэрүүлэн зуучлалд үүсэх зардал, ачааллыг Аргачлалын дагуу стандарт үйл ажиллагааг тодорхойлон, улмаар зарцуулах хугацааг нь гаргаж зардлын тооцоо хийх шаардлагатай.

Ингэхдээ шүүхэд үүсэж буй үүргийн стандарт үйл ажиллагааны хувьд Шүүгчийн ажлын ачаалал тодорхойлох судалгааг⁴ ашиглан хэрэгжүүлэх алхам,

⁴ Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүгчийн ажлын ачаалал тодорхойлох судалгаа, Хүснэгт 20. Шүүгчийн ажлын ачаалал тодорхойлох үзүүлэлт /Иргэний хэргийн анхан шатны шүүх/, хуудас 32.

хугацааг гаргасан. Тус судалгаанд үндэслэн шүүхийн байгууллагын гүйцэтгэх үүрэг, стандарт үйл ажиллагааг алхам тус бүрээр нарийвчлан тодорхойлж /Хавсралт 1/, түүнд зарцуулах нийт хугацааг дараах байдлаар гаргав. Үүнд:

Хүснэгт 10. Шүүхийн гүйцэтгэх үүрэг, стандарт үйл ажиллагаанд зарцуулах хугацаа

№	Үйл ажиллагаа буюу үүрэг	Зарцуулах хугацаа /цаг/
1	Шүүх хуралдааны бэлтгэл хангах: /хэргийн материалтай танилцах, нотлох баримт судлах/	60
2	Хэргийн хөдөлгөөний нэгдсэн систем дэх шүүгчийн ажиллагаа	30
	Нийт	90

Шүүх дэх эвлэрүүлэн зуучлалын хувьд ярилцлагад үндэслэн стандарт үйл ажиллагаа, тэдгээрийн дундаж хугацааг баримжаалан тогтоов. Үүнд:

Хүснэгт 10. Шүүх дэх эвлэрүүлэн зуучлагчийн үүрэг, стандарт үйл ажиллагаанд зарцуулах хугацаа

№	Стандарт үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа	Давтамж	Нийт хугацаа
1	Өргөдөл хүлээн авах	10	1	10
2	Өргөдөлтэй танилцах	10	1	10
3	Талуудтай холбогдох	15	5	75
4	Үулзалт хийх	60	3	180
5	Эвлэрлийн гэрээг бэлтгэх эсхүл дуусгавар болгох	30	1	30
6	Программ дээр ажиллах	15	1	15
7	Шүүхрүү материал илгээх, шүүхээс ирсэн материалыг программд оруулах	15	1	15
	НИЙТ			335 минут буюу 5 цаг 35 минут

Харин Хууль зүйн яамтай хийсэн ярилцлага, судалгаагаар ажлын албаны үүргийг гүйцэтгэхэд нэмэлт орон тоо шаардлагагүй гэж тогтоосон болно.

1.2. Ажил үйлчилгээг гүйцэтгэх хүний нөөц

Энэ хэсэгт төрийн байгууллагад хамаарах тогтоосон ажил үйлчилгээг хэрэгжүүлэхэд зарцуулах хугацаа болон жилд хэдэн удаа гүйцэтгэх тоог шаардагдах нийт ажлын цаг гэсэн 3 үзүүлэлтийг тооцож гаргадаг бөгөөд тус хуулийн төслийн хувьд энэ хэсэгт шүүх байгууллага болон шүүх дэх эвлэрүүлэн зуучлалд хамаарах үүргийг гүйцэтгэхэд шаардлагатай нийт хүний нөөцийг тооцож гаргана.

Ингэхдээ шинээр ирж буй үүрэгт зарцуулах хүний нөөцийг урьдчилан гаргахын тулд мөн холбогдох хэрэг маргааны төрөл тус бүрийн өмнөх жилүүдийн тоон үзүүлэлтийн дундажыг тооцоолон /судалгааны 1.3-д/ тохиолдлын тоог авч үзсэн. Үүнд:

Хүснэгт 12. Шүүхэд бий болох хүний нөөцийн хэрэгцээ /нийт цаг/

Маргааны төрөл /эвлэрэлийн гэрээг шүүгчийн захирамжаар баталгаажуулах болон шүүх дэх эвлэрүүлэн зуучлалаар шийдвэрлэх/	Зарцуулах хугацаа /цаг/	Тохиолдлын тоо	Хүний нөөцийн хэрэгцээ /нийт цаг/
--	-------------------------	----------------	-----------------------------------

Түрээсийн гэрээтэй холбоотой хэргийг 90 хянан шийдвэрлэсэн тоо 643 57870

Эд хөрөнгө хөлслөх гэрээтэй холбоотой хэргийг хянан шийдвэрлэсэн тоо 10 900

Сууц өмчлөгчдийн холбооны хэргийг 90 хянан шийдвэрлэсэн тоо 746 67140

Нийт 125820

Маргааны төрөл /эвлэрэлийн гэрээг шүүгчийн захирамжаар баталгаажуулах болон шүүх дэх эвлэрүүлэн зуучлалаар шийдвэрлэх/	Зарцуулах хугацаа /цаг/	Тохиолдлын тоо	Хүний нөөцийн хэрэгцээ /нийт цаг/
--	-------------------------	----------------	-----------------------------------

Түрээсийн гэрээтэй холбоотой хэргийг 335 хянан шийдвэрлэсэн тоо 643 215405

Эд хөрөнгө хөлслөх гэрээтэй холбоотой	335	10	3350
хэргийг хянан шийдвэрлэсэн тоо			
Сууц өмчлөгчдийн холбооны хэргийг	335	746	249910
хянан шийдвэрлэсэн тоо			
Нийт			468330

Улмаар нэг албан хаагч жилд 200 ажлын өдөр ажилладаг гэж үзвэл жилд 1600 цаг буюу 96000 минут ажиллах бөгөөд нийт шаардлагатай цагийг шаардлагатай орон тоонд шилжүүлэн шүүхийн байгууллага, хувьд авч үзвэл дараах тооцоо гарч байна. Үүнд:

Хүснэгт 13. Шүүх, шүүх дэх эвлэрүүлэн зуучлалын гүйцэтгэх үүрэг, стандарт үйл ажиллагаанд шаардлагатай хүний нөөцийн хэрэгцээ /орон тоо/

№	Байгууллага	Хүний нөөцийн хэрэгцээ /нийт цаг/	Хүний нөөцийн хэрэгцээ /орон тоо/
1	Шүүх	125820	1.3
2	Шүүх дэх эвлэрүүлэн зуучлал	468330	4.8

Өөрөөр хэлбэл хуулийн төслийн улмаас төрийн байгууллагуудад нийт **6**, үүнээс **ажлын албан**д яаманд нэмэлт орон тоо үүсэхгүй, **шүүхэд 1 орон тоо /шүүгч/, шүүхийн эвлэрүүлэн зуучлалд 5 орон тооны** ачаалал тус тус бий болгох тооцоо гарч байна.

1.3. Нийт гарах хүний нөөцийн зардлын тооцоо, холбогдох нэмэлт зардал

Нийт гарах хүний нөөцийн зардлын урьдчилсан тооцоо хийхэд дараах төрлийн зардлын мэдээлэл цуглуулав. Үүнд:

- Цалин, бусад нэмэгдэл, тусламж
- Ажлын байрны, цахилгааны болон бусад материаллаг зардал
- Дагалдах бусад зардал

Өмнөх хэсэгт **шүүхэд 1, шүүхийн эвлэрүүлэн зуучлалд 5 орон тоо** шаардлагатай гэж тооцсон. Иймд **НИЙТ 5** орон тоотой холбогдох хүний нөөцийн зардлыг тухайн байгууллагын цалингийн зэрэглэл тус бүрээр тооцох шаардлагатай болж байна.

Цалингийн хэмжээний тухайд байгууллага бүрт шаардлагатай орон тоо тус бүрээр цалингийн зэрэглэлийн дундаж цалингийн хэмжээг тогтоов. Үүнд:

Хүснэгт 14. Шаардлагатай орон тооны цалингийн зэрэглэл, хэмжээ

Албан тушаалын зэрэглэл	Албан тушаалын зэрэглэл	Сарын цалингийн хэмжээ /мян төг/
Шүүх	Анхан шатны шүүгч	4 000.000 ⁵
Шүүх дэх эвлэрүүлэн зуучлал	Шүүхийн ТҮ	3 000 000

Ийнхүү байгууллага тус бүрт шаардлагатай орон тооны сарын цалинг дунджаар тооцсон бөгөөд нийт шаардлагатай хүний нөөцийн цалингийн зардлыг байгууллага тус бүрээр дор тооцов. Үүнд:

Хүснэгт 16. Төрийн байгууллагын хүний нөөцийн нийт зардал

Нэмэгдэж буй ачаалал /орон тоо/	Цалингийн зардал /мян төг/	Хүний нөөцийн нийт зардал / сая төг/	Нийт зардал – 1 жилд /сая төг/
Шүүх /1 орон тоо - шүүгч/	4000000	4000000	48 000 000
Эвлэрүүлэн зуучлагч – 5 орон тоо	3000000	15000000	1 800 000 000

Түүнчлэн цалингаас гадна материаллаг зардлыг авч үзэх шаардлагатай бөгөөд эдгээр байгууллага нь шинээр бий болох орон тоог хангах материаллаг нөөцтэй гэж үзэн бичгийн ширээ, компьютер зэрэг тоног төхөөрөмж шинээр авахтай холбоотой зардал тооцоогүй бөгөөд харин эдгээртэй холбоотой элэгдэл, хорогдлын зардлыг тооцсон. Мөн материаллаг зардлын нарийвчилсан тооцоо гаргахдаа “Хуулийн төслийн үр нөлөө тооцох аргачлал”-д жишээ болгон авсан ХЗДХЯ-ы нэг ажилтны материаллаг зардлыг ашиглав. Үүнд:

Хүснэгт 17. Нэг албан хаагчид гарах материаллаг зардлын хэмжээ

Зардлын нэр	Зардлын төрөл	Хэмжээ /төгрөг/
Урсгал зардал	Бичиг хэргийн зардал	124,000

⁵ Үндсэн цалинг 2 700 000 төгрөгөөр тооцож, тодорхой нэмэгдлүүдийг нэмж тооцон ойролцоогоор бодов. Хавсралт 2-ыг харна уу.

	Ном, хэвлэл авах	54,745
	Шуудан холбоо	306,812
	Нийт	485,557
Барилга, байгууламж, өрөө тасалгааны зардал	Түлш, халаалт	263,408
	Гэрэл, цахилгаан	128,239
	Цэвэр, бохир ус	599,438
	Ургал зардал	127,752
	Газрын төлбөр	22,253
	Нийт	1,141,090
Элэгдэл, хороодлын зардал	Техник, тоног төхөөрөмж	160,000
	Тавилга, эд хогшил	100,000
	Барилга, байгууламж	65,670
	Нийт	325,670
Нийт		1,952,317

Дээрх тооцооноос үзэхэд нэг албан хаагчид гарах материаллаг зардлын хэмжээ дунджаар 1,952,317 төгрөг байна. Тус тооцоог ашиглан хуулийн төслийн улмаас төрийн байгууллага буюу төсөвт үүсэх нийт хүний нөөцийн ачаалал, зардлыг тооцож гаргав. Үүнд:

Хүснэгт 18. Төрийн байгууллагуудын 1 жилийн хүний нөөцийн нийт зардал

Байгууллага – шаардлагатай орон тоо	Хүний нөөцийн зардал	Материаллаг зардал /сая	Нийт зардал /сая төг/
--	-----------------------------	--------------------------------	------------------------------

/цалин, саяг төг/ төг/			
Шүүх /1 орон тоо - шүүгч/	46980000	1952317	49952317
Шүүх /5 орон тоо – эвлэрүүлэн зуучлагч/	1800000000	1952317	1801952317
Нийт			1851904634

Ийнхүү төрд 1 жилд нийт **1851904634** төгрөгийн хүний нөөцийн зардал нэмэгдэх, үүнээс шүүхийн эвлэрүүлэн зуучлалын хүний нөөцийн нийт зардал **1 тэрбум 800 сая**, шүүхэд нэмэгдэх хүний нөөцийн зардал **49 орчим сая** төгрөг байх тооцоо гарч байна.

1.4. Бусад нэмэлт зардал, нийт зардлын урьдчилсан тооцоо, хувилбар

Төсвийн зардал багасгах, ачаалал бууруулах, зохицуулалтын өөр хувилбар хэрэгжүүлэх боломж байгаа эсэхийг шалгах зорилгоор хуулийн төсөлтэй холбоотой гарч байгаа төрийн байгууллагад үүсэх бусад нэмэлт зардлыг энд авч үзэв.

Үүнд, хуулийн төсөлтэй холбоотой бусад нэмэлт хүний нөөцийн зардлын хувьд хуулийн төсөлд тусгасан орон тооны бус Эвлэрүүлэн зуучлалын хороо хүний нөөцийн зардлыг авч үзлээ. Хороо нь 7 гишүүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд даргыг нь гишүүдийн олонхын саналаар дотроосоо сонгоно.

Хууль зүй, дотоо хэргийн яамтай хийсэн ярилцлагын үеэр Хорооны гишүүд нь ажилласан цагаар хөлс бодогдох талаар тодруулга авсан бөгөөд гишүүд жилд хэдэн цаг ажиллахыг одоогийн байдлаар урьдчилан гаргах боломжгүй тул 1 гишүүн жилд ойролцоогоор 1,5 сая төгрөгийн цалин авах тооцоог дор гаргалаа.

Иймд орон тооны бус Хорооны нийт 7 гишүүний 1 жилийн цалингийн зардлыг тооцов⁶.

Хүснэгт 21. Орон тооны бус Хорооны цалингийн зардал

№	Хорооны нэр	1 цалин	жилийн /сая төг/	Тохиолдлын тоо /орон тоо/	Нийт зардал
1	Эвлэрүүлэн	зуучлалын	1500000	7	10500000

⁶ Стандарт үйл ажиллагаа тогтоо шаардлагагүй, тогтсон цалин тул энд тооцов.

хороо

Нийт	10500000
------	----------

Ийнхүү хуулийн төслийн хүрээнд бий болох орон тооны бус хорооны гишүүдийн цалин 1 жилд ойролцоогоор **10500000 төгрөгийн** зардал үүсгэх юм.

Үнэлгээний үр дүн

Тус хуулийн төслөөр иргэн, хуулийн этгээдэд шинээр үүрэг бий болгоогүй боловч шүүхээс гадуур урьдчилан шийдвэрлэх ажиллагаанд тооцогдох маргааны төрөл нэмэгдсэнтэй холбоотойгоор шүүхээс гадуурх эвлэрүүлэн зуучлалын дэмжлэгтэйгээр байгуулсан гэрээг шүүгчийн захирамжаар баталгаажулахад зардал, ачаалал үүсэх магадлалтай. Мөн эвлэрүүлэн зуучлах төв байгуулах, эвлэрүүлэн зуучлагчийн зөвшөөрөл авах зохицуулалтын хүрээнд захиргааны зардал үүснэ. Харин төрийн байгууллагын тухайд хуулийг хэрэгжүүлэгч байгууллагуудад тодорхой шинэ үүрэг бий болгосоноос гадна өмнө дурдсан зохицуулалтын хүрээнд шүүх болон шүүхийн дэргэдэх эвлэрүүлэн зуучлалын ачаалал нэмэгдэж болзошгүй юм. Үүнд:

Иргэн, хуулийн этгээдэд үүсэх зардал, ачаалал:

Тус хуулийн төсөлд өмнө нь байгаагүй цоо шинэ зохицуулалт үүсгэсэн буюу иргэн, хуулийн этгээдэд хамаарах үүрэг бий болгосон зохицуулалт тусгагдаагүй. Гэхдээ одоогийн хуульд байгаа ч шинэчлэл хийгдсэн зохицуулалт болох шүүхээс гадуурх эвлэрүүлэн зуучлалын дэмжлэгтэйгээр байгуулсан гэрээг шүүгчийн захирамжаар баталгаажуулах зохицуулалтын хүрээнд үүсэх магадлалтай зардал, ачааллыг авч үзэх шаардлагатай гэж үзэн зардлын тооцоолол гаргав. Энэ нь шүүхээс гадуур урьдчилан шийдвэрлэх ажиллагаанд тооцогдох маргааны төрөл нэмэгдсэнтэй холбоотойгоор үүсэх магадлалтай зардал, ачаалал болно.

Ийнхүү хуулийн төсөлд тусгагдсан тус зохицуулалтыг ашиглах шаардлага үүсэх магадлалтай **НИЙТ ТОХИОЛДЛООР** авч үзвэл иргээдэд **279600 минутын** ачаалал, хуулийн этгээдэд **31035600** орчим төгрөгийн зардлын ачаалал бий болох магадлалтай.

Эвлэрүүлэн зуучлах төв байгуулах, эвлэрүүлэн зуучлалын зөвшөөрөл авахад үүсэх захиргааны зардал:

Аргачлалд заасны дагуу шинээр үүссэн үүрэг, харилцаанаас үүсэх зардал, ачааллыг тооцох буюу өмнө байсан харилцааг зохицуулсан зохицуулалтад өөрчлөлт ороогүй бол зардал, ачааллыг тооцдоггүй. Энэ хүрээнд тус хуулийн төсөлд эвлэрүүлэн зуучлах төв байгуулах, эвлэрүүлэн зуучлалын зөвшөөрөл авахтай холбоотойгоор шинээр захиргааны үүрэг хүлээлгэсэн дараах зохицуулалт байна.

№ Холбогдох зохицуулалт

Тооцох зардал

Эвлэрүүлэн зуучлах төв байгуулах

1	10 дугаар зүйлд	Холбогдох бичиг баримт бүрдүүлж магадлан итгэмжлүүлэх хүсэлт гаргах
2	11 дүгээр зүйлд	Холбогдох нотлох баримт бүрдүүлж зөвшөөрөл авах хүсэлт гаргах

Эвлэрүүлэн зуучлалын зөвшөөрөл авах

Эдгээрийг биелүүлэхэд эвлэрүүлэн зуучлах төв байгуулах этгээд хуулийн төсөлд заасан захиргааны үүргийг биелүүлэхэд дунджаар **1760 мин** зарцуулж, харин эвлэрүүлэн зуучлалын зөвшөөрөл авах этгээд дунджаар **170 мин** зарцуулах тооцоо гарч байна.

Улмаар эвлэрүүлэн зуучлах төв байгуулах этгээд хуулийн төсөлд заасан захиргааны үүргийг биелүүлэхэд дунджаар **1760 мин** зарцуулах буюу **195360 төг** зарцуулах тооцоо гарч байна.

Төрийн байгууллагад үүсэх хүний нөөцийн зардал:

Төрийн байгууллагад үүсэх зардал, ачааллын хувьд хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон шүүх, шүүхийн дэргэдэх эвлэрүүлэн зуучлалд үүсэх зардал, ачааллыг тооцов. Үүнээс ХЗДХЯ-ны хувьд эвлэрүүлэн зуучлах төвийн талаарх зохицуулалтыг шинэчилсэнтэй холбоотойгоор шинээр үүсгэж буй бүтэц болох Хороо, түүний ажлын албыг зохион байгуулахад нэмэлт хүний нөөцийн зардал үүсэхгүй гэж үзсэн.

Шүүхийн байгууллагад үүсэх магадлалтай ачааллын хувьд шүүхээс гадуурх эвлэрүүлэн зуучлалын дэмжлэгтэйгээр байгуулсан гэрээ зөрчигдөж эхэлсэн үед шүүхэд гаргасан хүсэлтийг шийдвэрлэх, шүүгчийн захирамжаар баталгаажуулахтай холбоотойгоор шүүхийн ачаалал нэмэгдэх магадлалтай тул ачааллыг урьдчилан тооцох шаардлагатай гэж үзлээ. Энэхүү зохицуулалтын хувьд иргэн, хуулийн этгээдэд үүсэх зардал, ачаалалыг тооцоход авч үзсэнтэй адилаар шүүхээс гадуур урьдчилан шийдвэрлэх ажиллагаанд тооцогдох маргааны төрөл нэмэгдсэнтэй холбоотойгоор нэмэлт ачаалал үүсэх магадлалтай юм. Түүнчлэн тус зохицуулалтын хүрээнд шүүхийн эвлэрүүлэн зуучлалд нэмэлт ачаалал үүснэ.

Энэ хүрээнд төрд 1 жилд нийт **1851904634** төгрөгийн хүний нөөцийн зардал нэмэгдэх, үүнээс шүүхийн эвлэрүүлэн зуучлалын хүний нөөцийн нийт зардал **1 тэрбум 800 сая**, шүүхэд нэмэгдэх хүний нөөцийн зардал **49 орчим сая** төгрөг байх тооцоо гарч байна.

Хүний нөөцийн ачааллыг байгууллагаар авч үзвэл:

1	Шүүх /1 орон тоо - шүүгч/	49952317
2	Шүүх /5 орон тоо – эвлэрүүлэн зуучлагч/	1801952317

Түүнчлэн хуулийн төсөлтэй холбоотой бусад нэмэлт хүний нөөцийн зардлын хувьд хуулийн төсөлд тусгасан орон тооны бус Эвлэрүүлэн зуучлалын хороо хүний нөөцийн зардлыг авч үзлээ. Хороо нь 7 гишүүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд даргыг нь гишүүдийн олонхын саналаар дотроосоо сонгоно.

Хууль зүй, дотоо хэргийн яамтай хийсэн ярилцлагын үеэр Хорооны гишүүд нь ажилласан цагаар хөлс бодогдох талаар тодруулга авсан бөгөөд гишүүд жилд хэдэн цаг ажиллахыг одоогийн байдлаар урьдчилан гаргах боломжгүй тул 1 гишүүн жилд ойролцоогоор 1,5 сая төгрөгийн цалин авах тооцоог гаргав.

№	Хорооны нэр	1 жилийн цалин	Тохиолдлын /сая тоо /орон тоо/ төг/	Нийт зардал
1	Эвлэрүүлэн хороо	зуучлалын 1500000	7	10500000
	Нийт			10500000

Ийнхүү хуулийн төслийн хүрээнд бий болох орон тооны бус хорооны гишүүдийн цалин 1 жилд ойролцоогоор **10500000 төгрөгийн** зардал үүсгэх юм.

Хавсралт 1: Шүүхийн байгууллагад үүссэн ачааллыг тооцоход ашиглах стандарт үйл ажиллагааны хүснэгт

Хүснэгт 28. Шүүхэд үүсэх стандарт үйл ажиллагаа

	Үүрэг	Стандарт үйл ажиллагаа	Минут
1.	<i>Шийдвэр гаргах Хөнгөн хэрэг</i>	Хүсэлттэй танилцах, иргэний хэрэг үүсгэх эсэх асуудлыг шийдвэрлэх	10
		Шүүх хуралдааны бэлтгэл хангах: /хэргийн материалтай танилцах, нотлох баримт судлах/	60
		Шүүхээс гаргах эрх зүйн акт боловсруулах, хянах, албажуулах	30
		Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой хүсэлт, гомдол шийдвэрлэх	30
		Мэргэжлийн байгууллагын дүгнэлттэй танилцах	30
		Хэргийн хөдөлгөөний нэгдсэн систем дэх шүүгчийн ажиллагаа	30
		Хэргийн материалтай дахин танилцах, /хэрэг хянан шийдвэрлэхтэй холбоотой нотлох баримт хангалттай цугласан эсэхийг шалгах, дүгнэх/	60
		Шүүх хурлын өмнө гаргасан хүсэлт хэлэлцэх, хүсэлтийг шийдвэрлэх	20
		Шүүхийн шийдвэр гаргахаар зөвлөлдөх	30
		Шүүх хуралдааны шийдвэрийг талуудад танилцуулах	15
		Шүүхийн шийдвэр боловсруулах, хянах, албажуулах	60
		Шүүх хуралдааны тэмдэглэлийг хянах, баталгаажуулах	30

		Хэргийн хөдөлгөөний нэгдсэн систем дэх шүүгчийн ажиллагаа	33
		Давж заалдах, хяналтын гомдол хүлээн авах, холбогдох шүүхэд хэргийг хүргүүлэх	30
		Шүүхийн шийдвэрт гүйцэтгэх хуудас бичих	23
	<i>Шийдвэр гаргах</i> <i>Хүнд хэрэг</i>	Хүсэлттэй танилцах, иргэний хэрэг үүсгэх эсэх асуудлыг шийдвэрлэх	20
		Шүүх хуралдааны бэлтгэл хангах: /хэргийн материалтай танилцах, нотлох баримт судлах/	90
		Шүүхээс гаргах эрх зүйн акт боловсруулах, хянах, албажуулах	75
		Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой хүсэлт, гомдол шийдвэрлэх	45
		Мэргэжлийн байгууллагын дүгнэлттэй танилцах	45
		Хэргийн хөдөлгөөний нэгдсэн систем дэх шүүгчийн ажиллагаа	42.5
		Хэргийн материалтай дахин танилцах, /хэрэг хянан шийдвэрлэхтэй холбоотой нотлох баримт хангалттай цугласан эсэхийг шалгах, дүгнэх/	90
		Шүүх хурлын өмнө гаргасан хүсэлт хэлэлцэх, хүсэлтийг шийдвэрлэх	40
		Шүүхийн шийдвэр гаргахаар зөвлөлдөх	52.5
		Шүүх хуралдааны шийдвэрийг талуудад танилцуулах	20

	Шүүхийн шийдвэр боловсруулах, хянах, албажуулах	195
	Шүүх хуралдааны тэмдэглэлийг хянах, баталгаажуулах	45
	Хэргийн хөдөлгөөний нэгдсэн систем дэх шүүгчийн ажиллагаа	46.5
	Давж заалдах, хяналтын гомдол хүлээн авах, холбогдох шүүхэд хэргийг хүргүүлэх	30
	Шүүхийн шийдвэрт гүйцэтгэх хуудас бичих	38

Хавсралт 1: Төрийн албан хаагчийн цалингийн нэмэгдлийг тооцоход ашиглах хүснэгт

Цалингийн хэмжээг тогтооход үндсэн цалингаас гадна тодорхой нэмэгдлүүдийг⁷ тооцох шаардлагатай бөгөөд эдгээрийн хэмжээг тодорхой гаргах боломжгүй ч нийтлэг зардлыг үндсэн цалингийн 15%, дагалдах зардал болон нэмэгдэл, урамшууллыг 10%-аар тус тус тооцов. Үүнд:

Нэг албан хаагчид ногдох цалингийн зардал, шүүгчид 2700000 үндсэн цалингаар бодвол:

Үндсэн цалингийн дундаж хэмжээ	Нийтлэг зардал-15%	Дагалдах зардал-10%	Нэмэгдэл, урамшууллы н зардал-10%	Нийт цалин
791532	118729.8	79153.2	79153.2	1001288
Шүүгч				
Үндсэн цалингийн хэмжээ	Төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл- 5%	Онцгой нөхцлийн нэмэгдэл-40%		Нийт цалин
2700000	135000	1080000		3915000

⁷ Бүх төрлийн даатгал, хоол унааны нэмэгдэл, ажилласан жилийн нэмэгдэл, зэрэг дэвийн нэмэгдэл, шагнал урамшуулал зэрэг болно.

Хавсралт 3: Захиалагчаас ирүүлсэн хуулийн төсөл

[Судалгааны захиалагчаа ирүүлсэн хуулийн төслийг хавсаргав]